**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндалай сумын Нийтлэг үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ӨМА-2024/37/НА-СТА-ОНА**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өмнөговь аймаг<br>2024 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533539 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533539 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК<br>Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.03.15 № 276

танай ______ -ны № ______ -т

БАЯНДАЛАЙ СУМЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баяндалай сумын нийтлэг үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баяндалай сумын нийтлэг үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар 13,010.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсэгт заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Баяндалай сумын Засаг даргын Тамгын газартай Байгаль орчинд халгүй цогц менежмент хэрэгжүүлэх ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан байна.

## Аудитын гол асуудал

Байгууллага нь тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагааны хүрээнд 20,025.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

016020512

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 11,250.00 | 6,412,150.00 |
| 1.1.2 | Дансны авлага | - | 600,000.00 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **11,250.00** | **7,012,150.00** |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 948,085,712.36 | 931,441,760.24 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **948,085,712.36** | **931,441,760.24** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **948,096,962.36** | **938,453,910.24** |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | ӨР ТӨЛБӨР | - | - |
| 2.1.1 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 2.1.1.1 | Дансны өглөг | - | - |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | - |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **-** | **-** |
| 2.3 | **ЭЗДИЙН ӨМЧ** | **-** | **-** |
| 2.3.1 | -Төрийн | **-** | **-** |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 948,096,962.36 | 938,453,910.24 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **948,096,962.36** | **938,453,910.24** |
| **2.4** | **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **948,096,962.36** | **938,453,910.24** |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Өмнөх оны | Тайлант оны |
|---|---|---|---|
| 1 | Ажил, үйлчилгээ үзүүлсний орлого | 5,000.00 | 20,025,000.00 |
| 2 | Борлуулалтын өртөг | - | - |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал)** | **5,000.00** | **20,025,000.00** |
| 4 | Борлуулалт, маркетингийн зардал | - | 13,000,000.00 |
| 5 | Ерөнхий ба удирдлагын зардал | - | 16,668,052.12 |
| 6 | Бусад зардал | 12,650.00 | - |
| 7 | ҮХ элэгдэл, хорогдол | 16,643,952.12 | - |
| 8 | Бусад ашиг ( алдагдал) | - | - |
| **9** | **Татвар төлөхийн өмнөх (алдагдал)** | **(16,651,602.12)** | **(9,643,052.12)** |
| 10 | Орлогын татварын зардал | - | - |
| **11** | **Татварын дараах (алдагдал)** | **(16,651,602.12)** | **(9,643,052.12)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **964,748,564.5** | **964,748,564.5** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | **964,748,564.5** | **964,748,564.5** |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (16,651,602.12) | (16,651,602.12) |
| **5** | **2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **948,096,962.36** | **948,096,962.36** |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - |
| **7** | **Залруулсан үлдэгдэл** | **948,096,962.36** | **948,096,962.36** |
| 8 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (9,643,052.12) | **(9,643,052.12)** |
| **9** | **2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **938,453,910.24** | **938,453,910.24** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Өмнөх үеийн | Тайлант үеийн |
|---|---|---|---|
| 1 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн** | **5,000.00** | **19,425,000.00** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 5,000.00 | 19,425,000.00 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **12,650.00** | **13,024,100.00** |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | - | 13,000,000.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 12,650.00 | 24,100.00 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(7,650.00)** | **6,400,900.00** |
| **4.1** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(7,650.00)** | **6,400,900.00** |
| **5** | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **18,900.00** | **11,250.00** |
| **6** | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **11,250.00** | **6,412,150.00** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 16,643.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 16,643.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Орлого үр дүнгийн тайланд зардлын ангиллыг буруу бүртгэсэн нь НББОУС 1 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 16,643.9 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар нийт 13,010.0 мянган зөрчил[1] илэрснээс 13,010.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлогын дэлгэрэнгүй тайланд ерөнхий удирдлагын зардлыг ангилал буруу бүртгэсэн байна. | 1 | 16,643.9 | - | - | 1 | 16,643.9 | 1 | 16,643.9 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **16,643.9** | **-** | **-** | **1** | **16,643.9** | **1** | **16,643.9** | **-** | **-** | **-** | **-** |

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд 3,010.0 мянган төгрөгийн дараа тооцоо үүсгэсэн мөнгөн зарлагын ажил гүйлгээнд дараа тооцооны тайлан байхгүй, баримтын иж бүрдэл хангалтгүй байна. | 1 | 13,010.0 | - | - | - | - | 1 | 13,010.0 | - | - | - | - |
| Байгууллага үндсэн хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулсан баримт материалыг аудиторт ирүүлээгүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Байгууллага нь нягтлан бодогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **13,010.0** | - | - | **-** | **-** | **3** | **13,010.0** | - | - | - | - |

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.